

АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.12.02

№ 23

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1.	Мал тооллогын аймгийн комисс байгуулах тухай	Д.Тунгалаг		Тогтоол 90
2.	Татварын хувь хэмжээ тогтоох тухай	Д.Отгонбаяр		Тэмдэглэл
3.	Нэрэмжит болгох тухай	Алтайбаатар		Тогтоол 91
4.	Хамтын ажиллагааны "Тогтвортой хөгжил-Түншлэлийн зөвлөл" байгуулах тухай	Л.Батжаргал		Тогтоол 92
5.	Орон нутгийн зарим төлбөрийг шинэчлэн тогтоох тухай	Д.Амартүвшин		Тэмдэглэл

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 90

Есөнбулаг сум

Мал тооллогын аймгийн комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

- 1. Аймгийн мал тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Статистикийн хэлтсийн дарга

Гишүүд: Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Хүнс хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Олон нийтийн Алтай радиогийн сурвалжлагч

Статистикийн хэлтсийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн

- 2. Аймгийн хэмжээнд мал тооллогын ажлыг хуулийн хугацаанд нь малыг нүдээр үзэн тоолж, тооллогод хамрагдсан нийт өрхийн арван хувьд хяналтын тооллогыг чанартай зохион байгуулж, хариуцлагагүй хандсан ажилтан, албан хаагч, иргэдэд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллахыг мал тооллогын комиссын дарга, аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 91

Есөнбулаг сум

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлгэр сумын Гуулин тосгоны Соёлын төвийг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Улсын тэргүүний Ардын авьяастан Хоогиогийн Үүрцайх агсны нэрэмжит болгосугай.

2. Дэлгэр сумын Гуулин тосгоны Соёлын төвийг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Улсын тэргүүний Ардын авьяастан Х.Үүрцайх агсны нэрэмжит болсонтой холбогдуулан түүний гавьяа, ажил үйлсийг залуу хойч үеийнхэнд таниулж, алдаршуулан ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.



ДАРГА *В.Рэнцэндорж* П.БАТЖАРГАЛ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 92

Есөнбулаг сум

Хамтын ажиллагааны "Тогтвортой хөгжил –Түншлэлийн зөвлөл" байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "ж", 20 дугаар зүйлийн 20.1.7 дэх заалт, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тогтвортой хөгжил –Түншлэлийн зөвлөл" төслийн хүрээнд орон нутгийн хөгжилд төр, иргэний нийгмийн байгууллага, уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн тэгш оролцоог хангасан, түншлэлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий аймгийн хамтын ажиллагааны "Тогтвортой хөгжил-Түншлэлийн зөвлөл"-ийг 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсугай.

2. "Тогтвортой хөгжил –Түншлэлийн зөвлөл"-ийн талуудаас уг зөвлөлд төлөөлөн ажиллах гишүүдийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Зөвлөлийг ажиллах боломж нөхцөлөөр ханган шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

4. Сум орон нутгийнхаа хүрээнд салбар зөвлөл байгуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

ДАРГА  БАТЖАРГАЛ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн
92 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт



**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-
ТҮНШЛЭЛИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Аймгийн хамтын ажиллагааны “Тогтвортой хөгжил –Түншлэлийн зөвлөл ”
(цаашид “Зөвлөл” гэх)-д оролцох талуудыг төлөөлж ажиллана.

Дарга: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүдэд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч,
Төлөөлөгч

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
Зөвлөлийн нарийн бичгийн дарга: МҮХАҮТ-ын Говь – Алтай
салбарын менежер

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын
Хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХэлтсийн дарга

Аймгийн Татварын хэлтсийн дарга

Аймгийн иргэний Нийгмийн Нэгдсэн Зөвлөлийн тэргүүн

Аймгийн Барилгачдын Холбоо ТББ

Аймгийн ҮЭХолбоо

МҮХАҮТ-ын Говь – Алтай салбар танхим БЭЭЗөвлөл

“Баян –Таян” ХХК-ийн захирал

Ганчуб ХХК-ийн захирал

“Хүслийн наран” ХХК-ийн захирал

Алтайн Хүдэр ХХК-ийн үйл ажиллагааны захирал

Цэн Газар ХХК-ийн төслийн менежер

“Мандал-Голомт” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Алтай мэдээ сонины захирал

--oo0oo--